



ТӨСӨВ =

МӨНГӨ =

ХҮНИЙ ЭРХ

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хамгийн хурдан шуурхай, дэвшилттэй, үр ашигтайгаар хангахын тулд улс орнууд “боломжит бүх нөөцөө” ашиглах ёстой. Энэ зарчим нь цагийн хэцүүд ч, эдийн засгийн хямралтай үед ч, бусад төрлийн асуудалтай байсан ч ялгаагүй хүчин төгөлдөр хэрэгжих ёстой бөгөөд хүний эрхийг хангахад шаардагдах нөөц бүрдүүлэн, төвлөрүүлж, хуваарилах шийдвэр гаргахад нөлөөлнө.

НҮБ-ын Нэн Ядуурал ба Хүний эрх хариуцсан Тусгай Илтгэгч Магдалена
Сепулведа Кармона

ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

1 ТӨСӨВ ЯАГААД ХҮНИЙ ЭРХТЭЙ ХАМААРАЛТАЙ ВЭ?

Эдийн засаг, Нийгэм, Соёлын эрхийн тухай Олон улсын Пактын 2 дугаар зүйлийн 1-т:

“Энэхүү Пактад оролцогч улс бүр ... Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг бүрэн хэрэгжүүлэхийг дэвшилттэйгээр хангахын тулд хууль тогтоомжийн арга хэмжээг оролцуулан, зохистой арга хэмжээг байгаа бүх боломжийнхоо хэрээр авах үүрэгтэй” гэж заасан байдаг. Иймд засгийн газрууд хүний эрхийг хангах, хүндэтгэх, хамгаалах талаар олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө авсан амлалт, үүрэг, хариуцлагынхаа дагуу ажиллаж л байгаа бол энэ нь төсөвт тод томруун тусгагдсан байх ёстой.

Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, хянаж шалгах бүхий л үе шатанд хүний эрхийн зарчим, хэм хэмжээг баримтлах ёстой.

Хүний эрхэд ээлтэй төсөвтэй болсноор хүний эрхийг бодитоор хангах боломжтой болно. Хэдийгээр тухайн улс орны хууль, тогтоомж нь хүний эрхийг хангасан, хүний эрхэд ээлтэй байсан ч түүнийг хэрэгжүүлэх төсөвгүй, мөнгөний эх үүсвэр нь буруу байж болохгүй. Улсын төсвийг хүний эрхийн үүднээс судалснаар үндэсний баялгийг үр ашигтай, ил тод, шударга, хариуцлагатайгаар ашиглах оновчтой арга замыг олох боломжтой.

Хүний эрхэд ээлтэй төсөв гэдэг нь улсын төсвийг боловсруулах, дүн шинжилгээ хийхдээ хүний эрхийн хэмжүүр, зарчмыг ашиглахыг хэлнэ. Хүний эрхэд ээлтэй төсөв нь: 1. төсөв ба хүний эрхийн хамаарал, 2. хүний эрхэд суурилсан төсвийн дүн шинжилгээ гэсэн хоёр үйл ажиллагаанаас бүрддэг.

Түүнчлэн төсөвт хүний эрхийн өнцгөөс дүн шинжилгээ хийснээр хэн хэрхэн шийдвэр гаргаж байгаа, шийдвэр нь хэнд ямар нөлөө үзүүлж байгааг илүү ойлгомжтой болгоно. Ингэснээр эрүүл мэнд, нийгмийн халамж, боловсрол, шүүх, орон байр, хөдөлмөрийн зэрэг аль салбарт нэн тэргүүнд хөрөнгө оруулалт, санхүүжилт шаардлагатай байгааг олж харах, төсвийн залруулга, сайжруулалт хийж хүртээмжийг сайжруулан, амьдралын чанарыг дээшлүүлэх боломжтой болно.

Энэ үүднээс олон орон төсвийн хэрэгжилтээ дүгнэн хэлэлцэж, шинэчлэлт, сайжруулалтыг хийж байна.

2 ТӨСӨВТЭЙ ХОЛБООТОЙ ХҮНИЙ ЭРХИЙН ХЭМ ХЭМЖЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?

Улс орнуудын засгийн газар нь хүний эрхийг хүндэлж, хамгаалж, хангахын тулд хүний эрх зөрчсөн аливаа шийдвэр гаргахаас татгалзах, гуравдагч этгээдийн зүгээс хүний эрх зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийг хангахын тулд холбогдох хууль эрх зүй, захиргаа, төсөв, шүүх, нийгэм, боловсролын бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй:

Тухайлбал, Засгийн газар дараах гурван алхмыг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ:

- Пактад заасан бүх эрхийг “наад захын түвшинд” хэрэгжүүлэх (**Наад захын түвшин**),
- Хүний эрх “наад захын түвшинд” хэрэгжих нь эцсийн зорилго биш, суурь түвшин бөгөөд цаашид тасралтгүй ахиулах ёстой. (**Дэвшилттэй байх**),

- Хэрэв улс орны засгийн газар хүний эрхийг хэрэгжүүлэх явцдаа ямар нэгэн ухрах алхам зайлшгүй хийхэд хүрвэл энэ нь бүрэн үндэслэлтэй байх ёстой (**Ухрахгүй байх**).

3 ТӨСӨВТ ХЭРХЭН ХҮНИЙ ЭРХИЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ТУСГАХ ВЭ?

Хүний эрх, хүний эрхийн хэмжээ нь төсөвтэй хэрхэн уялдаж байгааг ойлгохын тулд төсөв ба хүний эрхийн хамаарал болон түүний дүн шинжилгээ гэсэн хоёр асуудлыг авч үзэх хэрэгтэй.

Хүснэгт 1: Хүний эрхийн хэм хэмжээнд суурилсан төсвийн үнэлгээ

	Төвлөрүүлэлт	Хуваарилалт	Зарцуулалт
Наад захын түвшин	Бүх хүний эрхийг наад захын түвшинд хангахад хүрэлцэхүйц нөөц бүрдүүлж чадсан уу?	Бүх хүний эрхийг наад захын түвшинд хангахад хүрэлцэхүйц нөөц хуваарилж чадсан уу?	Хуваарилсан төсвийг үр ашигтай зарцуулж чадсан уу?
Үл ялгаварлал	Нөөцийг хаанаас бүрдүүлж байна вэ? Төсөв бүрдүүлэлт нь нийгмийн зарим бүлэгт илүү хүнд тусаж байна уу?	Нийгмийн бүлэг хоорондын ялгаатай байдлыг арилгахад төсвийн хуваарилалт чиглэж чадсан уу?	Төсөв нь нийгмийн бүлгүүдэд ялгаатай зарцуулагдаж байна уу?
Дэвшилттэй, ухрахгүй байх	Төсвийн орлого нэмэгдэж (нэмэгдэх боломжтой) байна уу?	Хуваарилалтын хэмжээ нэмэгдэж эсвэл буурч байна уу? Буурсан бол хүндэтгэх шалтгаантай (хүний эрхийн талаас) юу?	Цаг хугацааны явцад санхүүгийн менежмент сайжирч эсвэл дордож байна уу?

Төсөв боловсруулах үйл явцад хүний эрхийн зарчим үйлчилж байгаа эсэхийг хэрхэн хянах вэ?

Төсөв боловсруулах үйл явцыг хүний эрхийн өнцгөөс авч үзэхийн тулд дараах шалгуур асуултыг тавих хэрэгтэй. Үүнд:

Ил тод байдал	- Төсвийг хэрхэн боловсруулсан бэ? - Төсөв болон төсвийг боловсруулах үйл ажиллагааны талаар мэдээлэл олон нийтэд хүртээмжтэй байж чадсан уу? Мэдээлэл нь ойлгоход хялбар байв уу? (Олон улсын сайн туршлагын жишгээр) - Төсвийн баримт бичгүүд нь хангалттай хугацаагаар олон нийтэд нээлттэй нийтлэгдсэн үү? (Олон улсын сайн туршлагын жишгээр) - Төсвийг “мөшгөх” боломжтой байсан уу?
Оролцоо	- Иргэдийн оролцоог хангахын тулд төсвийн баримт бичгийн иргэдэд зориулсан хувилбарыг хугацаанд нь боловсруулж, хүргэж чадсан уу? - Олон нийтийн болон иргэний нийгмийн байгууллагууд нь төсөв боловсруулах, сайжруулах, хянах бүхий л үе шатанд оролцох бодит боломжоор хангагдаж чадсан уу? - Төсвийн үйл явцад нийгмийн эмзэг бүлгүүдийн оролцоог хангасан уу?
Хариуцлагатай байдал	Төсвийн үйл явцад хяналт тавих бие даасан байгууллага болон үр дүнтэй эрх зүйн зохицуулалт байна уу? (Олон улсын сайн туршлагын жишгээр)

“Төсвийг хянаж, сайжруулахгүйгээр
эдийн засаг, нийгмийн эрхийн
хэрэгжилтийг хянах боломжгүй”

Ларри Кокс, Форд Сан, АНУ

